



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 13/02

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөрүүдийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.а, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 13/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арван гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Ахмад, залуу гэр бүл, өрх толгойлсон иргэдэд зориулсан түрээсийн орон сууц” дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, “Баянгол дүүргийн жендерийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг дүүргийн Засаг дарга /С.Одонтуяа/-д даалгасугай.

ДАРГА



Г.ЭНХБОЛД

1140100021

Хавсралт:

1. 1 дүгээр хавсралт: Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт болон бусад Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдаа;
2. 2 дугаар хавсралт: Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл тооцоо;
3. 3 дугаар хавсралт: Дэд хөтөлбөрийн төслийг нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудын багцалсан товъёг;
4. 4 дүгээр хавсралт: Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ;
5. 5 дугаар хавсралт: Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт;
6. 6 дугаар хавсралт: Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

Баянгол дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10
дугаар сарын 31 өдрийн 13/02 тоот
тогтоолын хоёрдугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Дэлхийн тогтвортой хөгжлийн 5-р зорилгод "Жендерийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх", Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-д "Нийгмийн хөгжил, дэвшилд жендерийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх", Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу хууль тогтоомж, бодлого төлөвлөлтийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлэх үйл явцыг дэмжих, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний арга зүйг нэвтрүүлэх, уг хуулийн 16.1.1-р зүйлд "Жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах", Монгол Улсын Засгийн газраас баталсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2017-2021/-т баталсан хөтөлбөрийн "Жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хөгжүүлэх" зорилгын хүрээнд салбаруудын жендерийн бодлого болон бүх аймаг, дүүргийн жендерийн дэд хөтөлбөр батлах" юм. Түүнчлэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Нийслэлийн Жендерийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ", "Орон нутгийн жендерийн дэд хөтөлбөр боловсруулах удирдамж", "дүүргийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл" зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан жендерийн чиглэлээр төрийн албан хаагчид болон олон нийтийн хэвшмэл хандлагыг өөрчлөх, хүний нөөцийг чадавхжуулах, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хамтын амьдралыг дэмжих, дүүргийн хэмжээнд жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чиглэлээр амжилтад хүрсэн гадаад, дотоодын байгууллага хамт олон, гэр бүлийн сайн

туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлнэ хэмээн заасан.

1.2. Швейцарын хөгжлийн агентлаг /ШХА/-ийн санхүүжилттэйгээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/GIZ/-ээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Монголын барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд "Нийслэл, дүүргүүдийн жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрүүдийг боловсруулах"-ад зөвлөх үйлчилгээг үзүүлж буй Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны багийн судлаачид "Нийслэлийн жендерийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ"-ний судалгааг 2018 оны 11 дүгээр сараас эхлэн 2019 оны 01 дүгээр сарыг дуусталх 3 сарын хугацаанд Улаанбаатар хот, нийслэлийн 9 дүүрэгт гүйцэтгэсэн. Судалгааны тайланг үндэслэн боловсруулсан болно.

Баянгол дүүрэгт Монгол Улсын нийт хүн амын 7 хувь, Нийслэл хотын хүн амын 15.2 хувь нь амьдарч байна. Нийслэл Улаанбаатар хотод нийт хүн амын 45 хувь нь оршин сууж байгаа бөгөөд нийт хүн амын 52 хувь нь эрэгтэй буюу 100 эмэгтэйд 92 эрэгтэй ногдож байна. Харин Баянгол дүүрэг нь хүн амын тоогоор Нийслэлийн 9 дүүрэг дунд гуравдугаарт орж байгаа бөгөөд засаг захиргааны нэгжийн хувьд 23 хороотойгоор иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. 2018 оны жилийн эцсийн байдлаас дүүрэг нь 59,536 өрхийн 226,869 хүн оршин сууж байгаагаас 106,732 нь эрэгтэйчүүд (47%), 120,137 нь (53%) эмэгтэйчүүд байна. Баянгол дүүргийн нийт хүн амын тоо 2017 оноос 780 өрх (1.3%), 5485 хүн (2.5%)-ээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Дүүргийн нийт хүн амын 63.0 хувь нь 34 хүртэлх насны залуучууд байна. Баянгол дүүргийн хүн амын нас хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 2010 онд 88.5 байсан бол 2018 онд 86.8 болж буурсан байна. Энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа, мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дунд эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой болно. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг сүүлийн 8 жилийн байдлаар авч үзвэл 2011 онд 4.8 хувь, 2012, 2013 онуудад 2 хувь, 2014 онд 4.3 хувь, 2015, 2016 онуудад 1.3 хувь, 2017 онд 3.7 хувь, 2018 онд 2.9 хувиар тус тус өссөн байна. 2011 онд хүн амын дундаж өсөлтийн хурд хамгийн их байсан бол 2015 болон 2016 онуудад хамгийн бага буюу 1,3 хувь байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг, үзлэг шинжилгээнд тогтмол хамрагддаггүй зэргээс эмчилгээний хугацаа алдах, улмаар эрсдэлд өртөх хувь хэмжээ өссөөр байна. Түүнчлэн 2018 оны байдлаар өвчлөлийн бус нас баралтын

шалтгааны нэгдүгээрт, амиа хорлол (387 эрэгтэй, 63 эмэгтэй), хоёрдугаарт, спиртэд санамсаргүй хордох, өртөх (353 эрэгтэй, 58 эмэгтэй) байгаагаас эрэгтэйчүүдийн тохиолдол илүү давамгайлж байна. Эрэгтэйчүүдийн дунд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахыг эрмэлздэг болгох хэрэгтэй байна. /Нийслэлийн хэмжээний тоо/

Баянгол дүүрэгт 2018 онд 1316 хүн нас барсан нь нийслэлд нас барсан нийт хүний 17.4 хувийг эзэлж байна. Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байдаг ба нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан нь болж байна.

Баянгол дүүрэгт 2018 онд 1253 хүн албан ёсоор шилжин ирж, 1329 хүн албан ёсоор шилжин явсан байна. 2018 онд 5561 хүүхэд шинээр мэндэлснээс 2910 нь буюу 52.3 хувь нь хүү, 2651 нь буюу 47.7 хувь нь охин байна. Амаржсан эхийн насны бүлгээр авч үзвэл 19 хүртэлх настай 3.2 хувь, 20-24 настай 20.6 хувь, 25-29 настай 32.9 хувь, 30-34 настай 24.5 хувь, 35-39 настай 14.7 хувь, 40-44 настай 3.8 хувь, 45-аас дээш настай 0.2 хувийг тус тус эзэлж байна.

2018 онд нийт 1157 өнчин хүүхэд бүртгэлтэйгээс 556 (48.1%) нь эмэгтэй хүүхэд байгаа ба 122 хүүхэд (10.5%) бүтэн өнчин, 1035 (89.5%) хүүхэд хагас өнчин байна. Харин 125 (10.8%) нь 0-4 насны, 329 (28.4%) нь 5-9 насны, 412(35.6%) нь 10-14 насны, 291 (25.2%) хувь нь 15-17 насны хүүхэд байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар дүүрэгт 5873 хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байгаа нь өмнөх оноос 1054 хүнээр өсжээ. Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 602 нь буюу 10.2 хувь нь 0-17 насны хүүхэд, 2785 нь буюу 47,4 хувь нь эмэгтэйчүүд байна. 6,1,4-р хороодод хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамгийн их байгаа бол 13,15-р хороодод хамгийн цөөн байна.

Баянгол дүүрэгт 2018 онд Улаанбаатар хотын нийт өрхийн 15.4 хувь буюу 59,536 өрх оршин сууж, нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.8 болсон байна. Нийт өрхийн тоо 2017 оноос 780 (1.3%) өрхөөр нэмэгдсэн байна.

Дүүргийн зарим үзүүлэлтүүдээс дурдвал:

	Өрхийн тоо	Хүн амын тоо			Тэтгэврийн насны хүн амын тоо		
		Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Нийт	59,536	226,869	106,732	120,137	20,010	5,669	14,341

2018 оны байдлаар нийт өрхийн 2.9 хувь нь 1602 өрх толгойлсон ганц бие өрхүүд байна. Ийм өрхүүдийн 88.5 хувь буюу 1419 нь эмэгтэй, 11.5 хувь буюу 183 эрэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.

Баянгол дүүрэгт 2018 онд гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 1581 байгаагаас 298 буюу 19% нь эмэгтэйчүүд байна. Нийслэлд гэмт хэргийн улмаас 2018 онд учирсан хохирлын 45.9 хувь нь Баянгол, 21.6 хувь нь Баянзүрх дүүрэг, 9.4 хувь нь Чингэлтэй дүүрэгт байгаа нь хамгийн өндөр байна. Гэмт хэргийн улмаас 9419 хүн, хуулийн этгээд хохирсон ба үүнээс 6338 буюу 67% нь эмэгтэйчүүд байгаа нь бусад дүүргээс хамгийн өндөр дүн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан 98 хүн байгаагийн 58 буюу 58.2% нь эхнэр, 8 буюу 8.2% нь нөхөр байна. Хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл бие махбодын 58, сэтгэл санааны 21, бэлгийн 1, эдийн засгийн 2 бүртгэгдсэн байна.

“Нийслэлийн жендерийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ”-ний ярилцлагын судалгаанд нийт 55 ажилтан, албан хаагч, иргэдийг хамруулсан. Судалгаанд оролцогчдын 86 хувь нь дүүргийн түвшинд жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр батлах хэрэгцээтэй гэсэн бол 14 хувь нь хэрэгцээгүй гэж үзсэн нь энэхүү хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага өндөр байгааг нотлон харуулсан.

Судалгаанд оролцогчид жендерийн дэд хөтөлбөрт дараах саналуудыг тусгасан байна.

- Ажилгүйдэл их, ажлын байр байхгүй, цалин бага байдгаас ядууралд өртөх нь их;
- Архидалт, түүнээс шалтгаалсан гэмт хэрэг, зөрчил түгээмэл байдаг;
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдалд хүндрэл их учирдаг;
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүртээмж бага бөгөөд хичээл орох тарах цаг тохиромж муутай

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлого батлагдсан. Үүнд мөн Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэй/эрэгтэйчүүдийн тэгш оролцоо, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэхийг заасан. Монгол Улс Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай тусгайлсан хуулийг 2011 онд батлан, Жендерийн үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө /2017-2021/-г хэрэгжүүлэн ажиллаж байна. Иймд Баянгол дүүрэг нь

Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Дэд хөтөлбөрийн зорилго

Дүүргийн хөгжлийн бодлого хөтөлбөрт жендерийн үзэл баримтлалыг тусгах, хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээнд жендерийн хэвшмэл үзэл буюу сөрөг хандлагыг өөрчлөх замаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад оршино.

2.2. Дэд хөтөлбөрийн зорилт

2.2.1 Төрийн албан хаагчдын жендерийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

2.2.2 Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендерийн боловсролыг олон нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах

2.2.3 Дүүргийн хүн ам, гэр бүл, охид хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй жендерийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөтөлбөрийг 2020-2025 онд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ:

Эхний үе шат 2020-2021 он

Сүүлийн үе шат 2022-2023 он

3.1. Төрийн албан хаагчдын жендерийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх гэсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд:

3.1.1. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиглэлээр туршлага судлах, түгээн дэлгэрүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг салбар салбарын чиглэлээр зохион байгуулах;

3.1.2. Төрийн албан хаагчдын жендерийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.3. Хамтарсан баг, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг жендерийн цогц стратегийн сургалтад хамруулах;

3.2. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендерийн боловсролыг олон нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах гэсэн зорилтын хүрээнд:

3.2.1. Жендер, жендерийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалт, жендерт суурилсан хүчирхийллийн талаар олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

3.2.2. Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах;

3.2.3. Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насны насныханд зориулан жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.4. Нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх;

3.3. Дүүргийн хүн ам, гэр бүл, охид хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй жендерийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэсэн зорилтын хүрээнд:

3.3.1. Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг /эх/-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендерийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих;

3.3.2. Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетыг дүүргийн эрүүл мэндийн төвд нээн ажиллуулах;

3.3.3. Түр хамгаалах байр буюу “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулах;

3.3.4. Архинаас хамааралтай иргэдийг эрүүлжүүлэх, амьдралын идэвхтэй болгон, ажлын байранд зуучлах чиглэлээр цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.3.5. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх;

3.3.6. Ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтныг чадавжуулах ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэн ажиллах;

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. Дүүргийн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, төсөв, хяналт-шинжилгээ, үнэлгээ жендерийн мэдрэмжтэй болно.

4.1.2. Жендерийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.

4.1.3. Нийгэмд жендерийн ялгаварлан гадуурхалт, жендерт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдал буурч гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт гарна.

4.1.4. Дүүргийн эмэгтэй, эрэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээл, тэгш бус байдлын саад тотгор багасна.

4.2. Дэд хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017)	хугацаанд үнэлэх түвшин	Зорилтот түвшин (2025)	Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд
1	Жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, тайланд хүйсээр ангилсан тоон мэдээлэл ашигладаг эсэх	Хувь	Ашигладдаггүй	50 хувь	100 хувь	БГД ЖТБ Дүн шинжилгээ	ТГХШУ Х

2	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг мэндийн кабинет	Тоо	0	1	1	ЭМТө в	ЗДТГ, ЭМТ
3	Жендерийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан хаагч	Хувь	УА-10% ТАХ-25%	УА-35% ТАХ-45%	УА-65% ТАХ-75%	БГД ЖТБ Дүн шинж илгээ	ЗДТГ, ЖЭТБХ СХороо
4	Жендерийн эрх тэгш байдлын талаарх хийгдэж буй сургалт, ажил үүрэгт хангалттай үнэлгээ өгөх ажилтан албан хаагчдын сэтгэл ханамжийн хувь	Хувь	14.5	64.5	85	БГД ЖТБ Дүн шинж илгээ	ЗДТГ, ЖЭТБХ СХороо
5	Түр хамгаалах байр буюу "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн тоо	Тоо	0	1	1	БГД ЖТБ Дүн шинж илгээ	ИТХ, ЗДТГ, ЖЭТБХ СХороо
6	Жендерийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн хувь	Хувь	15%	35%	65%	БГД ЖТБ Дүн шинж илгээ	ЗДТГ, ЖЭТБХ СХороо

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

5.1.2. Олон Улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

5.1.3. Бусад эх үүсвэр

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ, ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн Засаг даргаар ахлуулсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо ханган ажиллана.

6.2. Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж чанарын болон тоон үзүүлэлтийг ашиглан үр дүнгийн тайланг Жендерийн салбар хороонд танилцуулна.

6.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо нь хөтөлбөрийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР

7. Жендер: Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл хандлага
8. Жендерийн мэдрэмж: Эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг тодорхойлсон ойлголт.
9. Жендерийн статистик: Хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах, нэгтгэх, шинжлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах замаар жендерийн тулгамдсан асуудлыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох арга хэрэгсэл.
10. Жендерийн тэгш байдал: Эрэгтэй эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдсан байдал.
11. Жендерийн хэвшмэл ойлголт: Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаарх хялбаршуулсан ерөнхий ойлголт бөгөөд тэдний ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгахад садаа болж, шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.
12. Жендерийн мэдрэмжтэй төсөв: Нийгэмд жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого, төлөвлөлтийг дэмжсэн, түүнийг хэрэгжүүлэх төсөв, салбар, байгууллагын жендерийн чадавхыг сайжруулахад зориулагдсан тусгайлсан төсөв, тодорхой бүлгийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төсөв гэсэн хэлбэрүүдээр хэрэгжинэ.
Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах: Бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.